



ТАХЬКО (ХК) КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2015 оны 07 сарын 24 өдөр

Дугаар 10

Улаанбаатар

ТӨЛӨВЛӨГӨӨ БАТЛАХ ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1, Компанийн дүрмийн 7.2.2, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2015 оны 07 дугаар сарын 24-ний өдрийн хурлын шийдвэрийг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Тахько (ХК) компанийн 2015 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг нэгдүгээр хавсралтаар баталсугай.

2. Төлөвлөгөөний биелэлтэд хяналт тавьж, хэрэгжүүлж ажиллахыг Гүйцэтгэх захирал Л.Энхнасанд үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ХУРЛЫН ДАРГА



Л.БУЯНБАТ



Төлөөлөн удирдах зөвлөлийн 2015 оны 10 дугаар тогтоолын хэсэгт № 1

ТАХЬКО (ХК) КОМПАНИЙН 2015 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хэрэгжүүлэх арга хэмжээ	№	Хийж гүйцэтгэх ажил	Хугацаа	Зардлын хэмжээ (тегергээр)	Хэрэгжүүлэх алба
Нэг. Удирдлага, зохион байгуулалтын чиглэлээр					
Компанийн удирдлага, зохион байгуулалтын ажлын талаар	1	Компанийн ажлын байрны албан тушаалын жагсаалт, ангилал, лавлах, ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэн баталж, мөрдөх	I улиралд	-	Захиргааны алба
	2	Компанийн орон тоо, ажиллагсадын цалингийн хэмжээг шинэчлэн баталж, мөрдөх	I улиралд	-	Захиргааны алба
	3	Хөдөлмөрийн гэрээг Хөдөлмөрийн хууль, Хөдөлмөрийн дотоод журмын өөрчлөлттэй нийцүүлэн боловсруулж, нийт ажиллагсадтай шинээр гэрээ байгуулах	I улиралд	-	Захиргааны алба
	4	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинэчлэн, компанийн ажилтнуудад цалингийн урамшуулал олгох журам баталж, мөрдөх	I, III улиралд	-	Захиргааны алба
	5	2014 оны цэвэр ашгаас хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилах шийдвэр гаргуулж, ногдол ашгийг тарааж олгох, мэдээлэх, тайлагнах	I, II улиралд	97,578,606 341,500	Захиргааны алба
	6	Үнэт цаасны бүртгэл, хадгаламжийн гэрээг шинэчлэн байгуулж, арилжаа, хадгаламж, төлбөр тооцооны гэрээгээр хүлээсэн үүргийг хэрэгжүүлэх	Улирал тутамд	1,400,000	Захиргааны алба
	7	Компанийн тайлан, бусад мэдээллийг хувьцаа эзэмшигчдэд тогтмол мэдээлэх тухай Үнэт цаасны зах зээлийн хууль, Санхүүгийн зохицуулах хорооны шинэ журмыг хэрэгжүүлэх	Улирал тутамд	-	Захиргааны алба
	8	Мэргэжлийн зарим албан хаагчдыг эрх олгох, эрх сунгах, мэргэжлийн түвшин дээшлүүлэх сургалтад сургах	II-III улиралд	6,000,000	Захиргааны алба
	9	Компанийн ахмад настангуудад хүндэтгэл, тусламж үзүүлэх	I улиралд	3,290,000	Ахмад настны зөвлөл
				108,610,106	

ДҮН

Хоёр. Бизнесийн үйл ажиллагааны чиглэлээр				
Б. Бизнесийн үйл ажиллагааг өргөжүүлэх	10	Хүлэмжийн хийг бууруулах төслийг хэрэгжүүлэгч Клинтэк ХХК-тай хамтран ажиллах ажлыг үргэлжлүүлэх	Жилд	Төслийн баг
	11	Бүх төрлийн хог хаягдал, нүүрснээс шингэн түлш болон цахилгаан гаргаж авах төслийг эхлүүлэх	Жилд	120,000,000 (ЯОУХАБ-ын жижиг дунд үйлдвэрлэл, байгаль орчныг хамгаалах төслийн зээлээр)
	12	Магни үйлдвэрлэлийн төслийн судалгааны ажлыг үргэлжлүүлэх	Жилд	-
	13	Компанийн үл хөдлөх хөрөнгийн ирээдүйн хөгжлийн архитекторын зураг төслийн ажил	II улиралд	54,545,500
				174,545,500
ДҮН				
Гурав. Компанийн хэвийн үйл ажиллагааг хангах чиглэлээр				
В. Барилга байгууламжийн засвар, тохижилт, цахилгаан, сантехникийн хангамжийн хэвийн үйл ажиллагааг хангах	14	МА-II барилга (ТЕДИ төв)-ын дээвэр, фасадны их засварын ажил	II-III улиралд	67,766,000
	15	МА-III барилга (Анкор төв)-ын дээвэр, фасадны их засварын ажил	III улиралд	101,407,300
	16	Компанийн барилга байгууламж, цахилгаан, сантехникийн урсгал засварын ажлууд	Жилд	38,936,900
				208,110,200
ДҮН				
Дөрөв. Ажлын байрны хэвийн ажиллагааг хангах				
Г. Ажлын байрны нөхцөл боломжийг хангах	17	Онцгой байдал, галын аюулаас урьдчилан сэргийлэх	Жилд	1,320,000
	18	Хөдөлмөр хамгаалал, багаж хэрэгсэл, зарцуул мэнд	Жилд	5,621,000
				Төхник үйлчилгээний алба



	19	Оффисын төхөөрөмжийн үйлчилгээ, засвар, багаж хэрэгсэл	Жилд	9,880,000	Техник үйлчилгээний алба
ДҮН				16,821,000	
НИЙТ ДҮН				508,086,806	



ТАХЬКО ХК-ийн ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
 ЗАХИРГААНЫ АЛБАНЫ ДАРГА
 Л.ЭНХНАСАН
 Ц.ДОРЖГОТОВ



ТАХЬКО (ХК) КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2015 оны 07 сарын 24 өдөр

Дугаар 11

Улаанбаатар

АУДИТЫН ХОРООНЫ ДАРГА, ГИШҮҮДИЙГ СОНГОЖ ТОМИЛОХ ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 81 дүгээр зүйл, Компанийн дүрмийн 7.3 дахь заалт, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2015 оны 07 дугаар сарын 24-ний өдрийн хурлын шийдвэрийг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Аудитын хороог 3 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсугай.
2. Аудитын хорооны дарга, гишүүдийг доорхи бүрэлдэхүүнтэйгээр сонгож томилсугай.

Хорооны даргаар
Гишүүнээр

Б.Бямбасүрэн
С.Итгэл
Т.Доржготов

ТУЗ-ийн хараат бус гишүүн
ТУЗ-ийн хараат бус гишүүн
ТУЗ-ийн гишүүн

3. Компанийн тухай хуулийн 81 дүгээр зүйлийн 81.4, Компанийн дүрмийн 7.3.3 дахь заалтын дагуу Аудитын хорооны ажлыг зохион байгуулж ажиллахыг Аудитын хороо (Б.Бямбасүрэн)-нд даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ХУРЛЫН ДАРГА



Л.БУЯНБАТ



ТАХЬКО (ХК) КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2015 оны 07 сарын 24 өдөр

Дугаар 12

Улаанбаатар

НЭР ДЭВШҮҮЛЭХ ХОРООНЫ ДАРГА, ГИШҮҮДИЙГ СОНГОЖ ТОМИЛОХ ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 81 дүгээр зүйл, Компанийн дүрмийн 7.3 дахь заалт, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2015 оны 07 дугаар сарын 24-ний өдрийн хурлын шийдвэрийг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хороог 3 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсугай.
2. Нэр дэвшүүлэх хорооны дарга, гишүүдийг доорхи бүрэлдэхүүнтэйгээр сонгож томилсугай.

Хорооны даргаар
Гишүүнээр

С.Итгэл
Б.Сийлэгмаа
Т.Доржготов

ТУЗ-ийн хараат бус гишүүн
ТУЗ-ийн хараат бус гишүүн
ТУЗ-ийн гишүүн

3. Компанийн тухай хуулийн 81 дүгээр зүйлийн 81.5, Компанийн дүрмийн 7.3.4 дэх заалтын дагуу Нэр дэвшүүлэх хорооны ажлыг зохион байгуулж ажиллахыг Нэр дэвшүүлэх хороо (С.Итгэл)-нд даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ХУРЛЫН ДАРГА



Л.БУЯНБАТ



**ТАХЬКО (ХК) КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН
УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ**

2015 оны 07 сарын 24 өдөр

Дугаар 13

Улаанбаатар

**ЦАЛИН УРАМШУУЛЛЫН ХОРООНЫ ДАРГА,
ГИШҮҮДИЙГ СОНГОЖ ТОМИЛОХ ТУХАЙ**

Компанийн тухай хуулийн 81 дүгээр зүйл, Компанийн дүрмийн 7.3 дахь заалт, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2015 оны 07 дугаар сарын 24-ний өдрийн хурлын шийдвэрийг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Цалин урамшууллын хороог 3 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсугай.
2. Цалин урамшууллын хорооны дарга, гишүүдийг доорхи бүрэлдэхүүнтэйгээр сонгож томилсугай.

Хорооны даргаар
Гишүүнээр

Б.Батхуяг
Б.Сийлэгмаа
Б.Бямбасүрэн

ТУЗ-ийн гишүүн
ТУЗ-ийн хараат бус гишүүн
ТУЗ-ийн хараат бус гишүүн

3. Компанийн тухай хуулийн 81 дүгээр зүйлийн 81.6, Компанийн дүрмийн 7.3.5 дахь заалтын дагуу Цалин урамшууллын хорооны ажлыг зохион байгуулж ажиллахыг Цалин урамшууллын хороо (Б.Батхуяг)-нд даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ХУРЛЫН ДАРГА



Л.БУЯНБАТ